



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/658

Улаанбаатар хот

「Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын  
эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,531,400.00 (нэг сая таван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” ОНӨТҮГ-ын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар (Н.Баттулга)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” ОНӨТҮГ (Э.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* В. ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 0638 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар

| №                            | Эд хөрөнгийн нэр        | Ашиглалтанд авсан огноо | Чанар байдал | Хэмжээний хэлбэр | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ     | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэн авах байгууллага      |
|------------------------------|-------------------------|-------------------------|--------------|------------------|------------|-------------|--------------|-----------------------|----------------|---------------------------------|
| 1                            | Зурагт панасоник 55 инч | 12/30/2022              | сайн         | ш                | 2          | 765,700.00  | 1,531,400.00 | 255,233.34            | 1,276,166.66   | Төр захиргааны авто бааз ОНӨТҮГ |
| Машин тоног төхөөрөмжийг дүн |                         |                         |              |                  |            |             | 1,531,400.00 | 255,233.34            | 1,276,166.66   |                                 |
| Нийт хөрөнгийн дүн дүн       |                         |                         |              |                  |            |             |              |                       |                |                                 |